



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/121

Улаанбаатар хот

Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх
журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3, байгууллагын даргын 2016 оны А/214 дүгээр тушаалаар баталсан Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх журам”-ыг 1 дүгээр, “Эмнэлгийн анхан шатны болон яаралтай тусламж үзүүлэхэд шаардагдах, эм хэрэгслийн жагсаалт, эмнэлгийн хэрэгсэл, эмчийн өрөөний эд зүйлсийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг эмч /Х.Тогоосүрэн/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Д.Давааням/-т тус тус даалгасугай.


ДАРГА



Д.МӨРӨН

000000533

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2019 оны 04 дүгээр сарын 01 ний өдрийн
А/121 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт



ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Гадаадын иргэн, харьяатын газрын ажилтан, албан хаагчдад сувилахуйн анхны тусламж, үйлчилгээ үзүүлэхэд энэхүү журмыг баримтлан ажиллана.

Хоёр. Эмнэлгийн тусламж үзүүлэх

2.1. Эмнэлгийн тусламжийг мэргэжлийн эмч үзүүлнэ.

2.2. Үзлэг оношилгоо, эмчилгээг зориулалтын өрөө тасалгаанд хийнэ.

2.3. Эмнэлгийн анхны тусламжид дараах үйлчилгээ орно.

2.3.1. эмчийн үзлэг, оношилгоо, жор бичих, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх;

2.3.2. цусны даралт, зүрхний цохилт үзэх;

2.3.3. биеийн жин, өндөр үзэх, халуун үзэх;

2.3.5. нүд, чих хамар хоолойн анхан шатны үзлэг хийх;

2.3.6. сэхээн амьдруулах анхан тусламж үзүүлэх;

2.3.7. осол гэмтлийн үед анхан шатны ороолт боолт хийх;

2.3.8. судас тариа, булчин тариа, дусал хийх;

2.3.9. эмийн эмчилгээ;

2.3.10. зүү төөнүүр, бариа засал, бумба, хануур, шивүүр хийх;

2.3.11. физик эмчилгээ.

2.4. Шаардлагатай тохиолдолд өвчтөнийг нарийн мэргэжлийн харьяалагдах эмнэлэгт үзүүлэх зөвлөгөө, чиглэл өгнө.

Гурав. Эмчийн эрх, үүрэг

3.1. Яаралтай тусламжийн болон шаардлагатай тохиолдолд хэрэглэх эм, тариа, багаж, тоног төхөөрөмж, эмчийн хэрэгслийн төсвийн төслийг боловсруулна.

3.2. Шаардлагатай тохиолдолд яаралтай тусламжийн эм, тариа, хэрэгслийг хэрэглэж, зарлагыг тусгайлан бүртгэнэ.

3.3. Анхны тусламж авч үйлчлүүлсэн ажилтан, албан хаагчдын бүртгэл хөтөлнө.

3.4. "Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд ажилтан, албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1 удаа хамруулах ажлыг зохион байгуулна.

3.5. Яаралтай тусламжийн болон шаардлагатай эм, тариа, багаж хэрэгслийн зарцуулалтын тайланг санхүү хариуцсан нэгжид улиралд 1 удаа тайлагнана.

3.6. Эрүүл мэндийн талаар эрсдэлтэй бүлэгт хамаарах ажилтан, албан хаагчдын судалгааг гаргаж байнгын хяналтад оруулна.

3.7. Ажилтан, албан хаагчдын өвчлөлийн байдалд судалгаа хийж байгууллагын даргад танилцуулж, холбогдох арга хэмжээг авна.

3.8. "Эрүүл аж төрөх ёс" сэдвийн хүрээнд нарийн мэргэжлийн эмчийг урьж албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургалт, яриа таниулга зохион байгуулна.

3.9. Эм, ороох боох материалыг баталгаат эмийн сангаас худалдан авч эмийн түүврийн хуудас, эм олголтын бүртгэлийн дэвтэр хөтөлнө.

3.10. Хэрэв ажилтан, албан хаагч эмчийн заалтаар тариа хийлгэх бол өөрийн авч ирсэн эмчийн заалт болон тариа, тариураар үйлчлүүлнэ.

3.11. Цайны газар, албан тасалгаа болон ариун цэврийн өрөөнүүдийн эрүүл ахуй, ариун цэврийн байдалд өдөр тутам хяналт тавина.

3.12. Албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулна.

3.13. Эмнэлгийн тусгай хог хаягдлыг зориулалтын тусгай зөвшөөрөлтэй байгууллагатай гэрээ хийж устгуулахаар хүлээлгэн өгнө.

3.14. Байгууллагын байрны гадаад, дотоод орчинд эрүүл ахуйн хяналт тавьж, хуваарийн дагуу ариутгал халдваргүйтгэлийн ажлыг тогтмол хийлгэж, цэвэр орчныг бүрдүүлнэ.

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2019 оны 04 дүгээр сарын 01 ний өдрийн
А/121 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт

ЯАРАЛТАЙ БОЛОН АНХНЫ ТУСЛАМЖИЙН
ЭМ ТАРИАНЫ ЖАГСААЛТ

ЭМС-ын 2017 оны А/350 дугаар тушаалын
1 дүгээр хавсралтыг үндэслэв.

№	Эмийн нэр	Тун, туншил	Яаралтай тусламжийн шүүгээнд байх эмийн тоо ширхэг	Нөөцөд байх эмийн тоо ширхэг
1	2	3	4	5
1	Sol.Анальгин	50%-2мл	2 ампул	8
2	Sol.Адерналин	0,1%-1мл	2 ампул	3
3	Sol.Амикордин	2мл	2 ампул	3
4	Sol.Аминокапроны хүчил	40%-10мл	2 ампул	8
5	Sol.Маннитол	500мл	1 шингэн	1
6	Sol.Панангин	10мл	2 ампул	8
7	Sol.Атропин сульфат	1мг/мл	2 ампул	8
8	Sol.Баралгин	5мл	2 ампул	3
9	Sol.Викасол	1%-1мл	2 ампул	8
10	Sol.Кальцихлорид	10%-10мл	2 ампул	8
11	Sol.Кальцийн глюконат	10%-10мл	2 ампул	8
12	Sol.Глюкоз	40%-10мл	2 ампул	8
13	Sol.Дибазол	1%-2мл	2 ампул	8
14	Sol.Декстран 70	200мл	2 ампул	3
15	Sol.Демидрол	1%-1мл	2 ампул	8
16	Sol.Дексаметазон	4мг-1мл	2 ампул	3
17	Sol.Магнизм	25%-10мл	2 ампул	8
18	Sol.Фуросемид	40мг-2мл	2 ширхэг	8
19	Sol.Эуфиллин	24%-10мл	2 ампул	8
20	Sol.Но-шпа	40мг-2мл	2 ампул	8
21	Sol.Трамадол	1мл	2 ампул	3
22	Sol.Гордокс	10мл	2 ампул	3
23	Sol.Диклофенак	75мл	2 ампул	3
24	Sol.Церкулан	10мг-2мл	2 шингэн	8
25	Sol.Натрихлорид	0,9%-100мл	2 шингэн	8
26	Sol.Натрихлорид	0,9%-200мл	2 шингэн	8
27	Sol.Натрихлорид	0,9%-500мл	2 шингэн	8
28	Sol.Глюкоз	100мл/250мл	2 шингэн	8
29	Sol.Витамин 12	2мл	2 ампул	8
30	Sol.Рингер	200мл/500мл	2 шингэн	3
31	Sol Raimberin	500мл	1 шингэн	1
32	Sol.Калисмесь	100мл/250мл	2 шингэн	8
33	Sol.Никотины хүчил	10мг/1мл	2 ампул	8
34	Sol.Метрогел	100мг	3 шингэн	7
35	Sol.Кавинтон	5мг/литр	2 ампул	8
36	Sol.Пирацетам	10мг	2 ампул	8
37	Sol.Лидокайн	2%-1мл	2 ампул	8
38	Sol.Цефазолин	1,000,000	2 флакон	8
39	Деклоденк/лаа	100мл	2 ширхэг	3
40	Энап	5мг	1 таблетка	1
41	Валидол	0,5мг	2 таблетка	8
42	Диклоденк	100мг	2 таблетка	8
43	Веллергамин	0.25мл	1 таблетка	1
44	долоолгоны ханд	25гр	1 флакон	1
45	Панзинорм	0,5мг	2 таблетка	8
46	Налгезин	275мг	2 таблетка	3
47	Хлорфенамин	0,25мг	2 таблетка	3
48	Карболин	250мг	2 таблетка	8
49	Мезимфорте	500мг	2 таблетка	8

1	2	3	4	5
50	Валокордин	25мг	1 флакон	1
51	Атенолол	10мг	2 таблетка	8
52	Баралгин	0,5мг	2 таблетка	8
53	Каптоприл	0,5мг	2 таблетка	8
54	Бамбайн ханд	25мг	1 флакон	1
55	Ибупрофин	0,5мг	2 таблетка	8
56	Парацетамол	500мг	2 таблетка	8
57	Парацетамол/лаа	500мг	2 ширхэг	3
58	Омепразол	20мг/40мг	2 таблетка	8
59	Нитроглицирин	5мг	2 таблетка	8
60	Диратон	0,25	2 таблетка	8
61	Но-шпа	40мг	2 таблетка	8
62	Ципронол	500мг	2 таблетка	8
63	Амитриптиллин	75мг	2 таблетка	8
64	Хоросол 27.5г	100мг	1 ширхэг	1
65	Тамедин 0,7%	0,75мл	2 таблетка	3
66	Спирт 76%	100мл	2 ширхэг	8
67	Иод 3%	100мл	2 ширхэг	8
68	Хоромхон	25мг	2 ширхэг	8
69	Перекис 3%	25мл	2 ширхэг	3
70	Тариур	20.0гр	2 ширхэг	8
71	Тариур	10.0гр	2 ширхэг	8
72	Тариур	5.0гр	2 ширхэг	8
73	Тариур	3.0гр	2 ширхэг	8
74	Тетрациклин	1%-10гр	1 ширхэг	1
75	Калийн перманганат	1:10000	1 флакон	1
76	Дуслын систем	25	2 ширхэг	8

ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

№	Эмнэлгийн хэрэгслийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тайлбар
1	Хөвөн /ариутгасан/	боодол	5	Тариа хийх, цэвэрлэгээ хийх
2	Бинт /ариутгасан/	боодол	5	Боолт хийх
3	Хэл дарагч /1 удаагийн модон/	ширхэг	100	Үзлэг хийх
4	Шархны наалт /хурууны/	ширхэг	20	Шархны цэгцэлгээ
5	Шархны лент	ширхэг	20	Шархны цэгцэлгээ
6	1 удаагийн резинэн бээлий	ширхэг	100	Үзлэг хийх
7	Мэс заслын хутга /ир/	ширхэг	1 удаагийн хэрэглээ	
8	Эмнэлгийн хайч	ширхэг	1	Дунд зэрэг
9	Зүү баригч /жижиг/	ширхэг	1	
10	Мэс заслын нийлэг утас, зүүтэй	ком	2	Шархны цэгцэлгээ
11	Даавуун боолт төрөл бүрийн хэмжээтэй	боодол	4	Шарх бооход
12	Бүх төрлийн чигнүүд	ком	1-2	Хугарал мултралын
13	Малгай	ширхэг	10	
14	Амны хаалт	ширхэг	10	
15	Аюулгүй хайрцаг	ширхэг	10	Бохирлогдсон зүү тариур хийж устгах
16	Ахуйн хог хаягдлын сав	ширхэг	3	Хог хаягдал хийх

ЭМЧИЙН ӨРӨӨНД БАЙХ ЭД ЗҮЙЛСИЙН ЖАГСААЛТ

№	Эмнэлгийн хэрэгслийн нэр	Тоо ширхэг
1	Ширээ, сандал	1
2	Компьютер, принтер	1
3	Даралтын аппарат /автомат,механик/, чагнуур	1
4	Өндөр, жин хэмжигч	1
5	Үзлэгийн зориулалтын ор /эмчилгээний/	1
6	Яаралтай тусламжийн иж бүрдэл	1
7	Ердийн хөргөгч	1
8	Кварцийн гэрэл	1
9	Багажны шүүгээ	1
10	Бикс /дунд зэрэг/	1
11	Бумба, төөнүүр	10
12	Чангалуур	1
13	Туузан метр	1
14	Дуслын шингэний өлгүүр /штатив/	1
15	Эмнэлгийн хайч	1
16	Пинцет	1
17	Зүү баригч	1
18	Багажны тэргэнцэр	1
19	Эмийн шүүгээ	1
20	Бөөрөн хэлбэрт таваг	1
21	Халуун хэмжигч шил	1
22	Цахилгаан зүүний аппарат	1
23	Электрофорез аппарат	1
24	Термометр	1
25	УВЧ-шарлагын аппарат	1
26	Гар угаах угаалтуур	1
27	Ханын толь	1
28	Хувцасны шүүгээ	1
29	Өлгүүр	1
30	Муляж	1